

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн төслийн зорилт нь бизнесийн үйл ажиллагааг дэмжих, орчныг сайжруулах, иргэдийн орлогыг хамгаалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнесийн идэвхжилийг нэмэгдүүлэх, бүс орон нутагт ажиллах хүч, хөрөнгө оруулалт татах бүсчилсэн татварын бодлогыг хэрэгжүүлэх, албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулах бөгөөд уг хуулийн төсөлд төрийн байгууллага, хуулийн этгээд, хувь хүнд шинээр болон өмнө гүйцэтгэж байсан үүрэгт, нэмэгдсэн эсхүл хасагдсан чиг үүргийн хүрээнд тооцооллыг хийнэ.

Хууль тогтоомжийн тухай хууль -ийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/ батлагдсан нөхцөлд түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4-р хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж буйтай холбоотойгоор уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлын тооцоог боловсрууллаа.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход дор дурдсан нийтлэг зарчмыг баримтлах бөгөөд аргачлалд заасны дагуу хувь хүн, хуулийн этгээд, төрийн байгууллагын зардлыг тооцно.

- ✓ Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчлох тодорхойлох
- ✓ Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах
- ✓ Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах
- ✓ Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах

Тус хуулийн төсөлд төрийн байгууллага буюу татварын албаны хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагаа нэмэгдэх тул зардал тооцох шаардлагатай зохицуулалтуудыг түүвэрлэн, аргачлалын дагуу зардал тооцсон болно.

НЭГ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫГ ТООЦОХ

Хуулийн шинэчилсэн төслийг хэрэгжүүлэхэд Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Санхүү технологийн төв нь мэдээлэл солилцох, системд тохируулга, хөгжүүлэлт хийхээр уялдаа холбоотой ажиллана.

1. Хууль тогтоомжийн зохицуулалт

- Татварын ерөнхий хуулийн 25 дугаар зүйл Татвар төлөгчийн бүртгэл, 26 дугаар зүйл Татвар төлөгчийг бүртгэх нийтлэг журам

- Татварын ерөнхий хуулийн 30 дугаар зүйл Татварын тайлан хүлээн авах, тайлангийн боловсруулалт хийх, 31 дүгээр зүйл Татварын тайланд залруулга хийх
- Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн шинэчилсэн төсөл 15 дугаар зүйл Татвар тайлагнах, 22 дугаар зүйл 22.8 хялбаршуулсан горимд хамрагдсан этгээд тайлан ирүүлэх

Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт	Үүргийг хэрэгжүүлэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа
Хуулийн төслөөр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн өөрчлөгдсөн хэсэг		
Чиг үүрэг 1- Татвар төлөгчийн бүртгэл 7.1.Энэ хуулийн 4.1.3-т заасан борлуулалт хийж үйл ажиллагааны орлого олсон этгээд нь нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгч (цаашид “татвар суутган төлөгч”) болно 22.1.Дараалсан 12 сарын хугацаанд 400 сая төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой татвар суутган төлөгчийн хүсэлтээр татварын хялбаршуулсан горимд бүртгэнэ.	Монголын татварын алба	• Татвар төлөгчийн бүртгэлд үндэслэн нийт НӨАТ ногдуулах ибаримтын системийн хөгжүүлэлт, тохиргоог хийх • Хялбаршуулсан горим ашиглах хүсэлт илгээх, хянах, баталгаажуулах тохиргоог хийх • Татвар төлөгчид мэдэгдэх, хянах, бүртгүүлэхтэй холбоотой системийн тохиргоо, хөгжүүлэлтийг хийх • Дараалсан 12 сарын борлуулалтын орлогын дүнгээс хамаарч хялбаршуулсан горимын бүртгэлээс хасах, хасагдсанаас хойш 12 сарын хугацаанд дахин хүсэлт гаргахгүй байх системийн хөгжүүлэлт, тохиргоог хийх
Чиг үүрэг 2 – Тайлан хүлээн авах, тайлангийн боловсруулалт хийх, тайлангийн залруулга хийх 15.1.Татвар суутган төлөгч нь тухайн сарын татварын тайланг дараа сарын 10-ны өдрийн дотор харьяа татварын албанд цахимаар тушаана. 22.8.Хялбаршуулсан горимд хамрагдах татвар суутган төлөгч этгээд тухайн улирлын тайланг дараа сарын 10-ны өдрийн дотор харьяа татварын албанд цахимаар тушаана.	Монголын татварын алба	• Татвар төлөгчийн бүртгэлд үндэслэн хялбаршуулсан горим ашиглахаас бусад татвар төлөгчид сар бүр тайлан ирүүлэх, илгээх тохиргоог хийх • Татвар төлөгчийн бүртгэлд үндэслэн хялбаршуулсан горим ашиглах татвар төлөгчид улирлын тайланг дараа сарын 10-ны өдрийн дотор тайлан ирүүлэх, илгээх тохиргоог хийх • Татвар төлөгчид мэдэгдэх, хянах, бүртгүүлэхтэй холбоотой системийн тохиргоо, хөгжүүлэлтийг хийх
Чиг үүрэг 3 – Татвар төлөгчид үзүүлэх татварын хөнгөлөлт, урамшуулал	Монголын татварын алба	• Худалдан авалтын дүнд тохируулан буцаан олголтын хувь

6.1.Татвар төлөгчийн тухайн сарын 500,000 төгрөг хүртэлх худалдан авалтад төлсөн татварыг 100 хувь, 500,001-1,000,000 төгрөг хүртэлх худалдан авалтад төлсөн татварыг 50 хувь, 1,000,001 төгрөгөөс дээш худалдан авалтад төлсөн татварыг 20 хувиар хөнгөлж, олгоно.		хэмжээг тохируулах программын өөрчлөлт хийх - Татвар төлөгчид мэдэгдэх, хянах, бүртгүүлэхтэй холбоотой системийн тохиргоо, хөгжүүлэлтийг хийх 1 сараас- 45 хоногт буцаан олголтыг хийх системийн тохируулга, хөгжүүлэлтийг хийх
---	--	---

2. Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох:

Гүйцэтгэх үүрэг

- Нэмэгдсэн өртгийн албан татварыг ногдуулах, тайлангийн маягыг шинэчлэх, хүлээн авах, хянах
- Татварын системд тохируулга, хөгжүүлэлт хийх
- Татварын урамшуулалд олгох дүнг хянах, баталгаажуулах, буцаан олгох
- Татварын хялбаршуулсан горимд бүртгүүлэх хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх, бүртгэх, хасах, хяналт тавих
- Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч болон суутган төлөгчийн бүртгэл, тайлагнал, буцаан олголтын үнэн зөв байдлыг хангуулах, өөрчлөлт, залруулгыг хийх, шаардлагатай тохиолдолд татвар төлөгчөөр хийлгэх
- Нэмэгдсэн өртгийн албан татварыг төсөвт төвлөрүүлэх,

3.2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэхэд НӨАТсТ-ийн тоо 5 дахин, хүлээн авах тайлангийн тоо 10 дахин нэмэгдэнэ. Энэ хэмжээгээр татварын ерөнхий хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу зөвлөн туслах чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой албан хаагчдын ажлын ачаалал нэмэгдэнэ.

Албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт заасан чиг үүрэг, тайлан хүлээн авах, хянах, төсөвт төвлөрүүлэх чиг үүргийг гүйцэтгэх чиг үүрэг бүхий албан хаагчдын тоо зэрэгт үндэслэн хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой хүний нөөцийн нэмэлт хэрэгцээг тооцоход орон тоог татварын алба бүрд хамгийн багадаа нэгээр нэмэгдүүлэх шаардлагатай байна.

3.3. Гаргах зардлыг урьдчилан тооцох;

Өнөөгийн байдлаар 1,124 (том 25, дунд 22, жижиг 233, бичил 613, хувь хүн 231) татварын улсын байцаагч НӨАТ болон бусад хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хүний нөөцийн зардал

3.3.1. хүний нөөцийн цалингийн зардал

Нэг ажилтны цалингийн зардлыг татварын албанд мөрдөж буй цалингийн сүлжээ, хувь хэмжээг баримтлан тоймлон тооцоход дараах дүн гарч байна. Ажилтны цалин болон орон тоог 2024 оны гүйцэтгэлээр авсан болно. Үүнд:

- Үндсэн цалин төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээний ТЗ-7 зэрэглэлийн шатлалаар 1,539,000₮;
- Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг, төрийн албанд 11-15 жил ажилласан гэж үзэж 10%-ийн нэмэгдэл олгохоор;
- Зэрэг дэвийн хувьд гутгаар зэргийн дэс түшмэл гэж үзэж 17%-ийн нэмэгдэл олгохоор.

Нэг ажилтны цалингийн зардал = (үндсэн цалинг + нэмэгдлүүд)

- Сард $1,539,000₮ + 1,539,000₮ * 10\% + 1,539,000₮ * 17\% = 1,954,530.7₮$
- Жилд $1,954,530.7₮ * 12 \text{ сар} = 23,454,360.0₮$
- АО төлөх ЭМД болон НДШ $= 23,454,360.0₮ * 12,5\% = 2,931,795.0₮$
- Нэг хүний цалингийн сан /жилээр/ $= 26,386,155.0₮$

Татварын алба 2024 онд 1,834 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулсан бөгөөд үйл ажиллагааг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгө оруулалтын нийт 4,527,541.30 сая төгрөгийн зардал гарсан байна.

Материаллаг зардал

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэхэд ирүүлэх тайлангийн тоо 5-7 дахин, хүлээн авах тайлангийн тоо 10-11 дахин нэмэгдэж байгаатай холбоотойгоор ажиллах хүчний тоог нэмэгдүүлэхээс гадна татварын албаны серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, татварын цахим системд тохируулга, хөгжүүлэлт хийх, компьютер тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх, цаашид тухайн хуулийг хэрэгжүүлэх ажлын шаардлагаар мэдээллийн технологийн өргөтгөл, сайжруулалт, шинэчлэлийг төлөвлөх шаардлагатай. Хуулийн шинэчлэлтэй холбоотой татвар төлөгчийн хамрагдалт, өгөгдлийн сангийн цар хүрээ нэмэгдэх тооцооллын дагуу татварын албаны үндсэн болон дэмжих системүүдийн сервер болон түүний аюулгүй байдлыг хангах зорилготой.

Ашиглалтын үзүүлэлт өнөөгийн байдлаар дараах үзүүлэлттэй байна.

Дискийн нэр	АШИГЛАЛТЫН ХУВЬ
DATA	92.51%
RECO	47.91%

Хуулийн өөрчлөлттэй холбоотой хамрагдалтын тоон мэдээлэлд үндэслэн цаашид татварын албаны үндсэн болон дэмжих системүүдийн хүрээнд доорх бараа бүтээгдэхүүнүүдийг 2026 он болон 2027 онд хийж гүйцэтгэх шаардлагатай.

№	Мэдээллийн технологийн төрөл	Тоо ширхэг	Нийт шаардлагатай дүн	Үүнээс НӨАТ-ийн хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбоотой /56.33%/
1	Өгөгдлийн сан	4	11,632,113,700	6,552,369,647.21
2	Нөөц сервер	34	2,835,356,400	1,597,156,260.12
3	Сүлжээний аюулгүй байдал	6	2,134,600,500	1,202,420,461.65
	Switch, Storage, Data Protection	3	1,562,398,500	880,099,075.05
Нийт			18,548,822,200	10,232,045,444.03

Нийт 18,55 тэрбум төгрөгийн зардал шаардагдахаас НӨАТ-ын хуулийн шинэчлэлтэй холбоотой 56,33%-ийг зарцаална гэж тооцвол 10,23 тэрбум төгрөг шаардлагатай болно.

- Серверийн хүчин чадал нэмэгдүүлэх 10,23 тэрбум
- Компьютер, тоног төхөөрөмж 33 ширхэг, нэг бүрийн үнэ 2,0 сая төгрөг, нийт 66,0 сая төгрөг

Ингэснээр нийт 10,3 тэрбум төгрөгийн зардал гарахаар тооцов.

Бусад зардал

- Программ хангамжийн хөгжүүлэлт, тохируулга 200,0 сая төгрөг

3.4. Нийт дундаж зардал

Нийт дундаж зардал=(хүний нөөцийн зардал×хүний нөөцийн хэрэгцээ)+материаллаг зардал + бусад зардал

№	Зардлын төрөл	Тайлбар	Тоо	Нэгжийн үнэ ₮	Нийт	Давтамж	Дүн-жилээр ₮
1	Серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	НӨАТсТ-ийн тоо 5 дахин, хүлээн авах тайлангийн тоо 10 дахин нэмэгдэх	47		10,232,045,444.03	1	10,232,045,444.03
2	Программ хангамж тохируулах хөгжүүлэлт	Хуулийн шинэчлэлтэй холбоотой нэмэлт тохиргоо /хялбаршуулсан горим г.м/	5	40,000,000	200,000,000	1	200,000,000
3	Үндсэн болон нэмэгдэл цалин	33 алба тус бүр 1 хүн	33	1,954,530	64,499,490	12	733,993,880
4	Нийгмийн даатгалын шимтгэл	Даатгуулагч болон ажил олгогчийн төлөх НДШ 24%		469,087.2	15,479,877.6	12	185,758,531.2
5	Компьютер, тоног төхөөрөмж	Шинэ албан хаагчдад	33	2,000,000	66,000,000	1	66,000,000
Нийт							11,417,797,855.23

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага буюу татварын албаны зүгээс нийт 11.42 тэрбум төгрөгийн нэмэлт зардал гаргахаар байна.

3.5. Хялбарчлах боломжийг нягталж, үр дүнг танилцуулах.

Татварын албаны серверийн хүчин чадлыг нэмэгдүүлж, программ хангамжийн тохируулга, хөгжүүлэлтийг сайн хийснээр ажиллах хүчний ачааллыг бууруулах, систем гацах зэрэг сөрөг талуудыг бууруулах боломжтой.

ХОЁР. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДЛЫГ ТООЦОХ

Уг хуулийн төсөлд зааснаар хуулийн этгээд нь борлуулалтын орлогодоо нэмж нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах ба уг дүнгээс аж ахуйн үйл ажиллагааны зориулалтаар худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд төлсөн болон импортын бараанд төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг хасаж тайлант хугацаанд төлбөл зохих татвар, эсхүл татварын илүү төлөлтийн дүнг тодорхойлно.

2.1. Хууль тогтоомжийн зохицуулалт

Нэмэгдсэн өртгийн албан татварыг суутган төлөгчийн албан татварын тайлан нь сар бүр буюу жилд 12 удаа, хялбаршуулсан горимд хамрагдсан бол жилд 4 удаа гаргаж, тайлангаар ногдуулсан татварыг төсөвт төлөхөөр тусгасан.

- Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйл Татварын тайлан үйлдэх, тушаах
- Татварын ерөнхий хуулийн 31 дүгээр зүйл Татварын тайланд залруулга хийх
- Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн шинэчилсэн төсөл 15 дугаар зүйл Татвар тайлагнах, 22 дугаар зүйл 22.8 хялбаршуулсан горимд хамрагдсан этгээд тайлан ирүүлэх

2.2. Гүйцэтгэх үүрэг

- Санхүүгийн анхан шатны баримт /и баримт/-ыг бүрдүүлэх
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан гаргах, тушаах
- Хялбаршуулсан горимд хамрагдах бол хүсэлт гаргах, шийдвэрлүүлэх
- Тайлангаар ногдуулсан нэмэгдсэн өртгийн албан татварыг төсөвт төлөх

2.1 Зардлыг тооцох:

Зардлыг тооцохдоо Нэмэгдсэн өртгийн албан татварын 2024 оны тайлангийн үзүүлэлтэд үндэслэн ААН-ийг борлуулалтын орлогын хэмжээгээр нь гурав ангилан авч үзлээ. Үүнд:

- a. 400.0 сая төгрөгөөс дээш- уг аж ахуйн нэгжүүдийн хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хамгийн багадаа 3-5 (дунджаар 4) нягтлан бодогч орон тоогоор ажиллах шаардлагатай. .
- b. 0- 400.0 сая төгрөг хүртэл- эдгээр аж ахуйн нэгжүүдийн хувьд хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хамгийн багадаа 1-3 (дунджаар 2) нягтлан бодогч орон тоогоор ажиллах шаардлагатай.

Энд нягтлан бодогч гэдэгт Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.6-д заасан мэргэжлийн нягтлан бодогчийг ойлгоно. /"мэргэжлийн нягтлан бодогч" гэж их, дээд сургууль, коллежийг нягтлан бодогчийн мэргэжлээр бакалавр буюу түүнээс дээш зэргээр төгссөн хүнийг/

Аргачлалын 2.4.4-д заасны дагуу тухайн үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагаа болон түүнд зарцуулах хугацааг тус аргачлалын хүснэгт 1-т тодорхойлсон загварын дагуу доор байдлаар тодорхойлов.

Хүснэгт №1.1 ААН-үүдийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацаа /цагаар/

№	Ерөнхий үйл ажиллагаа	0-400.0 сая хүртэл	400.0 саяас дээш
1	Чиг үүргийн дагуу хууль тогтоомж, түүний нэмэлт өөрчлөлт судлах	25	5
2	Мэдээлэл цуглуулах / харилцагчийн болон салбарын мэдээлэл/	20	15
3	Мэдээлэл, ажил гүйлгээ, өгөгдлүүдийг нягтлах	30	15
4	АШБ-ийн маягт болон НББ-ийн маягт хөтлөх бүртгэх	40	20
5	Харилцагч талуудтай тооцоо нийлэх, акт үйлдэх	35	25
6	Төлбөр тооцоо хийх, мөнгөн шинжүүлэг хийх	25	5
7	Мэдээ, тайлан бэлтгэх, танилцуулах, тушаах	45	15
8	АШБ болон НББ-ийн маягт архивлах	33	15
9	Дотоод хуралдаан /зөвлөгөөн/	30	20
10	Бусадтай хамтран хийх хуралдаан /зөвлөгөөн/	20	10
11	Төрийн захиргааны байгууллагаас шалгах шалгалт, засвар, дахин тайлагнал	25	15
12	Сургалт, давтан сургалтын арга хэмжээнүүд	8	8
Нийт ажлын цаг		336	168
Үүнээс НӨАТ-Х хэрэгжүүлэхэд зарцуулах цаг		23.3	29.6

Нэг сарын ажлын цаг 168, НӨАТ-ын тайланг сард нэг удаа татварын албанд хүргүүлнэ гэж үзэн холбогдох тооцооллыг хийсэн. Энд аж ахуйн нэгжийн борлуулалтын орлогын дүнгээс хамааран НӨАТ-ын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой хугацаа нь ангилал бүрийн хувьд харилцан адилгүй бөгөөд 12.5-23.3 цаг байна.

Аргачлалын 2.4.2-д заасны дагуу тухайн үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай ажлын хөлсийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож тодорхойлбол ангилал тус бүрээр дараах байдалтай байна .

Хүснэгт №1.2. Ажлын хөлс - сараар /мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	0-400.0 сая төгрөг хүртэл	400.0 сая төгрөгөөс дээш
1	1 сарын үндсэн цалин	792,0	792
2	Ажиллах хугацаа /цагаар/	23.3	29.6
3	Ажлын хөлс-нэг сараар/мянган төгрөг/	109.6	139.4

Аргачлалын 2.4.6-д заасны дагуу тухайн үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлын дүн ангилал тус бүрээр дараах байдалтай байна .

Хүснэгт №1.3. Ажлын хөлс – нийт /мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	0-400.0 сая төгрөг хүртэл	400.0 сая төгрөгөөс дээш
1	Үндсэн орон тоо	1.5	3
2	Ажлын хөлс-нэг сараар/мянган төгрөг/	109.6	139.4
3	ААН-ийн тоо /2024 онд тайлан өгсөн 176637/	137,871	38,766
4	Ажлын хөлс- сараар, нийт /сая төгрөг/	10,107.8	12,747.1

Аж ахуй нэгжийн борлуулалтын орлогын дүнгээс хамааран тухайн аж ахуйн нэгжийн шууд зардлын дүн нь сар тутамд 58.9-328.8 мянган төгрөгийн хооронд байх бөгөөд нэг аж ахуйн нэгжид ногдох жинлэсэн дундаж зардал нь 129.4 мянган төгрөг байна.

2.3. Тоон үзүүлэлтийг тооцох:

Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланг одоо хүчин төгөлдөр мөрдөж буй хуулийн дагуу 2024 онд 58,183 ААН ирүүлсэн. Хуулийн шинэчилсэн төслөөр НӨАТсТ-өөр бүртгүүлэх борлуулалтын орлогын босго дүнг 50.0 сая төгрөгөөр тогтоосон заалтыг хассан тул 2024 онд үйл ажиллагаа явуулж, ААНОАТ-ын тайлан гаргаж ирүүлсэн нийт 176,637 ААН сар бүр НӨАТ-ын тайлан гаргана. /Тоон үзүүлэлт=Тохиолдлын тоо × Давтамжийн тоо/

Хүснэгт №1.4. Жилд хүлээн авах тайлангийн тоо

№	Үзүүлэлт	0-400.0 сая төгрөг хүртэл	400.0 сая төгрөгөөс дээш	Дүн
1	ААН-ийн тоо /2024 онд тайлан өгсөн 176637/	137,871	38,766	176,637
2	НӨАТсТ-ийн үүрэг хэрэгжүүлэх-сар бүр	4	12	
3	Жилд хүлээн авах тайлангийн тоо	671,484	465,192	1,136,676

1.4. Нийт зардлын дүнг тооцох: Нийт зардал=Зардал × Тоон үзүүлэлт

Хүснэгт №1.5. Нийт зардал

№	Үзүүлэлт	0-400.0 сая төгрөг хүртэл	400.0 сая төгрөгөөс дээш	Дүн
1	ААН-ийн тоо /2024 онд тайлан өгсөн 176637/	137,871	38,766	176,637
2	НӨАТсТ-ийн үүрэг хэрэгжүүлэх-сар бүр	4	12	
3	Жилд хүлээн авах тайлангийн тоо	671,484	465,192	1,136,676
4	Ажлын хөлс-жилээр, нийт /сая төгрөг/	40,431.2	152,965.10	193,396.3

Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн шинэчилсэн төслөөр ААН-үүд жилд нийт 1,14 сая тайлан бэлтгэж ирүүлэх бөгөөд үүнд нийт 193.4 тэрбум төгрөгийн нийт зардал гаргахаар байна.

1.5. Хялбарчлах боломж:

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд НӨАТсТ-өөр бүртгүүлэх борлуулалтын орлогын босго дүнг тогтоосон заалтыг хассан боловч үргэлжилсэн 12 сарын борлуулалтын орлогын дүн 400.0 сая төгрөгөөс доош ААН-үүд хүсэлт гаргах замаар хялбаршуулсан горимд шилжих сонголтыг бий болгосон. Зарим жижиг ААН орон тооны нягтлан бодогч биш гэрээт нягтлан бодогч ажиллуулах замаар зардлыг бууруулах боломжтой.

Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбоотойгоор татвар төлөгч хуулийн этгээдийг үүрэгдүүлсэн татвар төлөгчийн бүртгэл хийлгэх, татварын хяналт шалгалтад хамруулахтай холбоотой хувь хүний зүгээс гарах зардлыг бууруулах боломжийг дараах шалгууруудаар тодорхойлъя. Үүнд:

а) Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх:

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд зааснаар үргэлжилсэн 12 сарын борлуулалтын орлогын дүн 400.0 сая төгрөгөөс доош ААН-үүд эхний жилд ирүүлэх хүсэлтийн тоо дараагийн татварын жилээс буурах, хялбаршуулсан бүртгэлээс хасагдсан аж ахуйн нэгж жилийн хугацаанд дахин хүсэлт гаргахгүй тул хүсэлт болон тайлангийн давтамж өөрчлөгдөнө. Цахим тайлангийн системд хялбаршуулах программын хөгжүүлэлтийг хийх боломжтой.

Хүснэгт №1.4. Жилд хүлээн авах тайлан, хүсэлтийн тоо

№	Үзүүлэлт	0-400.0 сая төгрөг хүртэл	400.0 сая төгрөгөөс дээш	Нийт
1	ААН-ийн тоо /2024 онд 176637/	137,871	38,766	176,637
2	НӨАТсТ-ийн үүрэг хэрэгжүүлэх	4	12	
3	Жилд хүлээн авах тайлангийн тоо	551,484	465,192	1,016,676
4.	Хялбаршуулсан горим ашиглах хүсэлтийн тоо	137,871		137,871
5	Нийт хүлээн авах хүсэлт, тайлангийн тоо	689,355	465,192	1,154,547

б) Давтамжийг багасгах боломж байгаа эсэх:

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд хялбаршуулсан тайлан ирүүлэх сонголтыг оруулсантай холбоотойгоор 2024 оны жилийн эцсийн ААН-ийн мэдээлэлд үндэслэн тооцвол 50.0 сая төгрөг хүртэл борлуулалтын орлоготой нийт 137,871 татвар төлөгч хялбаршуулсан горимд шилжих боломжтой. 50,0 сая төгрөгөөс дээш орлоготой НӨАТ суутган төлөгчөөр бүртгэлтэй 25,356 аж ахуйн нэгжийн сар бүр тайлагнах давтамж буурах боловч, тайлан ирүүлдэггүй 112,515 татвар төлөгч улирал бүр тайлан ирүүлэхээр болж байгаа нь нөлөөлөхүйц өөрчлөлтийг үзүүлэхгүй.

в) Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх:

Хуулийн этгээд нь НӨАТсТ-өөр бүртгэлтэй тохиолдолд тайлангийн маягт өөрчлөгдөхгүй тул мэдээллийн агуулга багасахгүй. Харин хялбаршуулсан горимоор бэлтгэж буй тайлангийн агуулга зөвхөн борлуулалтын орлого, түүнд ногдуулан тооцсон татварын дүнгээр хязгаарлагдах тул мэдээллийн агуулга эрс багасна.

г) Шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх;

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд НӨАТсТ-өөр бүртгүүлэх борлуулалтын орлогын дүнг хассан тул үйл ажиллагаа явуулж байгаа бүх ААН НӨАТсТ-өөр бүртгүүлэх, сар бүр НӨАТ-ын бүртгэл хөтлөн тайлан ирүүлэх үүрэг хүлээсэн. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөж буй хуулиар 2024 онд 58,183 хуулийн этгээд НӨАТ-ын тайлан ирүүлж байсан бол,

хуулийн шинэчилсэн төслөөр 2024 онд үйл ажиллагаа явуулж, ААНОАТ-ын тайлан гаргаж ирүүлсэн нийт 176,637 хуулийн этгээд бүгд тайлан ирүүлэх үүрэгтэй болсон.

д) Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх;

Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланг цахимаар болон цаасан хэлбэрээр тайлагнах боломжтой бөгөөд 2024 оны байдлаар тайлан тушаасан бүх хуулийн этгээд 100 хувь нь цахимаар тайлангаа ирүүлсэн байна.

е) мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх;

Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланг зөвхөн татварын албанд хүргүүлдэг тул мэдээлэл хүргүүлэх байгууллагын тоо багасахгүй.

ё) нэг цэгийн үйлчилгээ бий болгох боломжтой эсэх гэх мэт;

Татварын алба татвар төлөгч хуулийн этгээдэд нэг цэгийн үйлчилгээ үзүүлдэг. 2024 онд үйл ажиллагаа явуулж, тайлан ирүүлсэн бүх хуулийн этгээд ААНОАТ болон НӨАТ-ын тайлангаа 100 хувь цахимаар илгээсэн.

1.6. Нэмэлт зардлыг тооцох.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар бүх хуулийн этгээд НӨАТсТ-өөр бүртгүүлэх шаардлагатай болсон. Иймээс өмнө нь НӨАТ-ын тайлан гаргах үүрэггүй (Борлуулалтын орлогын хэмжээ 50.0 сая төгрөг хүртэл) байсан нийт 118,454 хуулийн этгээд гэрээт нягтлан бодогчоор нягтлан бодох бүртгэлээ хөтлүүлэн, тайлангаа гаргадаг байсан бол одоо орон тооны нягтлан бодогчтой болох хэрэгцээ үүсэж байна. Үүнийг дагаад ажлын байрны түрээсийн төлбөр, эд хөрөнгийн элэгдэл хорогдол, цахилгаан дулаан, бичиг хэрэг, техник, тоног төхөөрөмж, урсгал болон хөрөнгө оруулалт гэх мэт нэмэлт зардал гарна. Үүнд нэг ААН-д дунджаар 1 сая төгрөгийн зардал гарна гэж тооцвол

Ажлын байрны зардал = $118,454 * 1,000,000 = 118.5$ тэрбум төгрөг

Мөн эдгээр ААН хялбаршуулсан горим бүгд хялбаршуулсан горим ашиглахаар бүртгүүлнэ гэвэл улиралд нэг удаа буюу жилд 4 удаа тайлан гаргаж, цахимаар илгээнэ. Тайлангаар тодорхойлогдсон татварыг улирал бүрийн дараа сарын 15-ны дотор төлөх үүрэгтэй. Нэг удаагийн банкны шимтгэлийн зардал 200₮ бол улиралд $118,454 * 200₮ = 23.7$ сая төгрөг, жилд $118,454 * 200₮ * 4$ удаа = 94.8 сая төгрөгийн банкны шимтгэлийн зардал нэмэлтээр гарна.

ХОЁР. ИРГЭНИЙ ЗАРДЛЫГ ТООЦОХ

Уг хуулийн төсөлд зааснаар хувиараа үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн нь НӨАТсТ-өөр бүртгүүлэхээр болсон.

Иргэн нь НӨАТсТ нь хялбаршуулсан горимоор бүртгүүлэх хүсэлт гаргасан бол НӨАТ-ын тайланг улиралд 1 удаа буюу жилд 4 удаа, хүсэлт гаргаагүй бол сар бүр буюу ба жилд 12 удаа гаргахаар тусгасан.

Гүйцэтгэх үүрэг

- Төлбөрийн баримт олгох хэрэглэгчийн системийг шийдэх
- Санхүүгийн анхан шатны баримт /и баримт/-ыг бүрдүүлэх
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан гаргах, тушаах
- Нэмэгдсэн өртгийн албан татварыг төсөвт төлөх

1.2. Зардлыг тооцох:

Зардлыг тооцохдоо хууль хэрэгжүүлэхтэй холбоотой үүргийг гэрээт нягтлан бодогчоор гүйцэтгүүлнэ гэж тооцсон бөгөөд 2024 онд хувь хүний орлогын албан татварын тайлангийн үзүүлэлтэд үндэслэн иргэнийг үйл ажиллагааны орлогын хэмжээгээр нь гурав ангилан авч үзлээ. Үүнд:

- с. Борлуулалтын орлогын хэмжээ 400.0 сая төгрөгөөс дээш. Уг иргэн хялбаршуулсан горим ашиглах хүсэлт гаргах боломжгүй тул сар бүр НӨАТ-ын тайлан бэлтгэж, харьяа татварын албанд тушаана. Гэрээт нягтлан бодогчид сард хамгийн багадаа 500.0 мянган төгрөг төлнө гэж тооцсон. 2024 оны байдлаар энэ ангилалд 1,646 иргэн хамрагдаж байна.
- д. Борлуулалтын орлогын хэмжээ 0-400.0 сая төгрөг хүртэл. 2024 оны байдлаар энэ ангилалд 124,594 иргэн хамрагдаж байгаа бөгөөд хялбаршуулсан горим ашиглах хүсэлт гаргасан тохиолдолд улиралд нэг удаа тайлан гаргана. НӨАТ-ын хуулийн хэрэгжүүлэхтэй холбоотой чиг үүргийг сар бүр тогтмол хэрэгжүүлэх тул гэрээт нягтлан бодогчид сард хамгийн багадаа 150.0 мянган төгрөг төлнө гэж тооцсон.

Энд гэрээт нягтлан бодогч гэдэгт Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.14-д заасан гэрээт нягтлан бодогчийг ойлгоно. /"гэрээт нягтлан бодогч" гэж гэрээгээр нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэх, мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөлтэй мэргэжлийн нягтлан бодогчийг/

Аргачлалын 2.4.2-д заасны дагуу тухайн үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай ажлын хөлсийг тодорхойлбол ангилал тус бүрээр дараах байдалтай байна.

Хүснэгт №2.1 Ажлын хөлс /мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	0-400.0 сая төгрөг хүртэл	400.0 сая төгрөгөөс дээш	Нийт
1	Гэрээт нягтлан бодогчийн ажлын хөлс-сар	150	500	
2	НӨАТ-ийн үүрэг хэрэгжүүлэх иргэний тоо	124,594	1,646	126,240
3	Ажлын хөлс-сараар /мянган төгрөг/	6,753,450	246,900	7,000,350

Хувиараа бизнес эрхэлж буй иргэний борлуулалтын орлогын дүнгээс хамааран хууль хэрэгжүүлэх шууд зардлын дүн нь сард 50.0-150.0 мянган төгрөгийн хооронд байх бөгөөд нэг иргэний төлөх жинлэсэн дундаж зардал нь сард 55.4 мянган төгрөг байна. Бизнесийн орлоготой нийт 126,240 иргэний хувьд энэ дүн нь сард 7.0 тэрбум төгрөг болно.

1.3. Тоон үзүүлэлтийг тооцох:

Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланг одоо хүчин төгөлдөр мөрдөж буй хуулийн дагуу НӨАТ-ын тайланг иргэн улирал, сар бүрээр гаргана. /Тоон үзүүлэлт = Тохиолдлын тоо × Давтамжийн тоо/

Хүснэгт №2.2. Жилд хүлээн авах тайлангийн тоо

№	Үзүүлэлт	0-400.0 сая төгрөг хүртэл	400.0 сая төгрөгөөс дээш	Дүн
1	НӨАТ-ийн үүрэг хэрэгжүүлэх иргэний тоо	124,594	1,646	126,240

2	НӨАТсТ-ийн үүрэг хэрэгжүүлэх- сар бүр	4	12	
3	Жилд хүлээн авах тайлангийн тоо	498,376	19,752	518,128

1.4. Нийт зардлын дүнг тооцох: Нийт зардал=Зардал × Тоон үзүүлэлт

Хүснэгт №2.3. Нийт зардал

№	Үзүүлэлт	0-400.0 сая төгрөг хүртэл	400.0 сая төгрөгөөс дээш	Дүн
1	НӨАТсТ-ийн үүрэг хэрэгжүүлэх иргэний тоо	124,594	1,646	126,240
2	НӨАТсТ-ийн үүрэг хэрэгжүүлэх- сар бүр	4	12	
3	Жилд хүлээн авах тайлангийн тоо	498,376	19,752	518,128
4	Ажлын хөлс- жилээр, нийт/тэрбум төгрөгөөр/	162.08	9.88	171.96

Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн шинэчилсэн төслөөр бизнес эрхэлдэг иргэд жилд нийт 1.5 сая тайлан бэлтгэж ирүүлэх бөгөөд үүнд нийт 84,0 тэрбум төгрөгийн нийт зардал гаргахаар байна.

1.5. Хялбарчлах боломж:

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөл тусгаснаар үйл ажиллагааны орлогын хэмжээ 400.0 сая төгрөгөөс доош 124,594 иргэн хялбаршуулсан горим ашиглахаар хүсэлт гаргах, тайлангийн бүрэн цахимжуулах замаар тайлагнах үйл ажиллагааг хялбаршуулах боломжтой.

а) Давтамжийг багасгах боломж байгаа эсэх:

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд хялбаршуулсан тайлан ирүүлэх сонголтыг оруулсантай холбоотойгоор 2024 оны жилийн эцсийн мэдээлэлд үндэслэн тооцвол 400.0 сая төгрөг хүртэл борлуулалтын орлоготой нийт 124,594 татвар төлөгч хялбаршуулсан горимд шилжих боломжтой. 50,0 сая төгрөгөөс дээш орлоготой НӨАТ суутган төлөгчөөр бүртгэлтэй 12,121 иргэн сар бүр тайлагнах давтамж буурах боловч, тайлан ирүүлдэггүй 114,119 татвар төлөгч улирал бүр тайлан ирүүлэхээр болж байгаа нь нөлөөлөхүйц өөрчлөлтийг үзүүлэхгүй.

в) Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх:

Хуулийн этгээд нь НӨАТсТ-өөр бүртгэлтэй тохиолдолд тайлангийн маягт өөрчлөгдөхгүй тул мэдээллийн агуулга багасахгүй. Харин хялбаршуулсан горимоор бэлтгэж буй тайлангийн агуулга зөвхөн борлуулалтын орлого, түүнд ногдуулан тооцсон татварын дүнгээр хязгаарлагдах тул мэдээллийн агуулга эрс багасна.

д) Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх;

Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланг цахимаар болон цаасан хэлбэрээр тайлагнах боломжтой бөгөөд 2024 оны байдлаар тайлан тушаасан бүх иргэн 100 хувь нь цахимаар тайлангаа ирүүлсэн байна.

е) мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх;

Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланг зөвхөн татварын албанд хүргүүлдэг тул мэдээлэл хүргүүлэх байгууллагын тоо багасахгүй.

ё) нэг цэгийн үйлчилгээ бий болгох боломжтой эсэх гэх мэт;

Татварын алба татвар төлөгч хуулийн этгээдэд нэг цэгийн үйлчилгээ үзүүлдэг. 2024 онд үйл ажиллагаа явуулж, тайлан ирүүлсэн бүх иргэн ХХОАТ болон НӨАТ-ын тайлангаа 100 хувь цахимаар илгээсэн.

1.6. Нэмэлт зардлыг тооцох.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр үйл ажиллагааны орлого бүхий иргэд гэрээт нягтлан бодогчоор нягтлан бодох бүртгэлээ хөтлүүлэн, тайлангаа гаргана гэж тооцсон тул татвар төлөхтэй холбоотой банкны шимтгэлийн зардлаас өөр нэмэлт зардал гарахгүй. Татварын тайлангаар төлөхөөр тооцсон татварыг шилжүүлэхэд нэг удаагийн шимтгэлийн зардлыг 200₮ гэж тооцоход, нийт 518,1 мянган удаагийн шилжүүлгийн хувьд $518.1 \times 200₮ = 103.6$ сая төгрөгийн нэмэлт зардал гарна.